



127

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 5 сарын 18

№ 146

Улаанбаатар
хот

Гал түймэртэй тэмцэх хэлтэс
байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 90 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гал түймэртэй тэмцэх хэлтсийг хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд 1991 оны 5 дугаар сарын 20-ноос байгуулсугай.

2. Нийслэл хотод хоршоо, хувийн үйлдвэр, нүүс олноор байгуулагдаж гал түймэртэй тэмцэх байгууллагын анхаарлын гадна орхигдсон, мөн Налайх хотын дэвсгэр нутаг тэлж, хүн ам өсч галын тоо, хохирол тууштай буурахгүй байгааг харгалзан улсын галын байцаагчийн орон тоог хоёроор нэмэгдүүлсүгэй.

3. Улаанбаатар хотын Гал түймэртэй тэмцэх хэлтэс, түүний харьяа Налайх, Багануур, Багахангайн дүүрэг, Туул хорооны гал унтраах ангиудад төсөв болон төсвийн гадуур хөрөнгийн данс нээн ажиллуулахыг хотын Санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

4. Гал унтраах мэргэжлийн ажилтнуудад амьсгалахад хүнд нөхцөл, хүчтэй үйлчилгээтэй хорт бодис бүхий орчинд гарсан галыг унтраахаар хүчилтөрөгчөөр тусгаарлагдсан /КИП-8/ багтай ажилласан I цаг тутамд 40 төгрөгний нэмэгдэл олгож байхыг зөвшөөрсүгэй.

5. Гал унтраах ур чадвар, дасгал сургуулийн гол үндэс болсон мэргэжлийн галын техникийн олон төрөлт спортын бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг Улаанбаатар хотод зохион байгуулахад шаардагдах төсөв хөрөнгийг гаргаж улмаар хөрш зэргэлдээ ЗХУ болон БНХАУ-ын баг тамирчидтай хоёр жилд нэг удаа нөхөрсөг уулзалт тэмцээн зохион явуулахыг хотын Гал түймэртэй тэмцэх хэлтэс

2.

/н.Ганхуяг/, Биеийн тамир спортын хороо /н.Солномзундуй/ -нд зөвшөөрсүгэй.

6.Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ажилтнуудын ажлын онцлогийг харгалзан орон сууц, хуваарилан олгож байхыг хот нийтийн аж ахуй эрхэлсэн дэд дарга /н.Баасанжав/-д, тэдний бага насны хүүхдүүдийг оршин суугаа газарт нь ойролцоо өдрийн болон 24 цагийн ажиллагаатай үзвэрлэг, яслид тэргүүн ээлжинд оруулж байхыг Боловсролын газар /н.Чимэддорж/-д, байнгын бэлэн байдалд жижүүрлэгчдэд шаардагдах махан бүтээгдэхүүнээр хангаж байхыг Хүнсний бараа худалдааны нэгдэл /н.Бадарч/-д тус тус шаалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

[Handwritten signature]

Л.ЭНЭБИШ

Ч.СУМААХҮҮ

[Handwritten signature]